

Гээгдсэн тоонууд

Нумера-д хоёр тоон дараалал байсан ба 2 тоон дараалал нь нэгнийхээ сэлгэмэл.

Харамсалтай нь тэрээр нэг үзүүлэнгээс нөгөө үзүүлэн рүү тоон дараалалаа зөөж байхдаа эхний дарааллаас зарим

тоо нь гээгдсэн. Та гээгдсэн тоонуудыг түүнд олоход туслаач.

Жишээ нь:

Дутсан буюу 1-р дараалал нь $arr = \{7, 2, 5, 3, 5, 3\}$ ба бүтэн байгаа буюу 2-р дараалал нь $brr = \{7, 2, 5, 4, 6, 3, 5, 3\}$.

Алга болсон тоонууд нь $\{4, 6\}$.

Тэмдэглэл

Хэрвээ тоо дараалалд нэгээс олон удаа орсон бол та хоёр дараалалд хоёуланд нь адил давтамжтай байгаа эсэхийг баталгаажуулаарай.

Хэрвээ үгүй бол тоо гээгдсэн байна гэсэн үг.

Гээгдсэн тоонуудыг өсөх дарааллаар хэвлэнэ үү.

Гээгдсэн тоо бүрийг нэг удаа хэвлэнэ үү. Хэдийгээр тэр тоо олноор алга болсон байсан ч гэсэн.

2 дахь дарааллын хамгийн их ба бага тоонуудын зөрүү нь 100-аас бага буюу тэнцүү.

Функцийн тайлбар

MissingNumbers гэдэг функцийг бичнэ үү. Өсөх дарааллаар алга болсон тоонуудыг хэвлэх үүрэгтэй.

MissingNumbers доорх өгөгдөлийг хүлээн авна

- Arr: дутсан тоон дараалал
- Brr: бүрэн бүтэн байгаа тоон дараалал

Оролтын бүтэц

Дөрвөн мөрөнд тоонууд өгөгдөнө.

Эхний мөрөнд бүхэл тоо n , n , arr дарааллын урт

Дараагийн мөрөнд n ширхэг зайгаар тусгаарлагдсан бүхэл тоонууд $arr[i]$ өгөгдөнө.

3 дахь мөрөнд бүхэл тоо m , m , brr дарааллын урт

Дараагийн мөрөнд m ширхэг зайгаар тусгаарлагдсан бүхэл тоонууд $brr[i]$ өгөгдөнө.

Хязгаарлалт

$$1 \leq n, \quad m \leq 2 \times 10^5$$

$$n \leq m$$

$$1 \leq brr[i] \leq 10^4$$

$$X_{\max} - X_{\min} < 101$$

Гаралтын бүтэц

Алга болсон тоонуудыг өсөх дарааллаар хэвлэ.

Жишээ

Оролт

10

203 204 205 206 207 208 203 204 205 206

13

203 204 204 205 206 207 205 208 203 206 205 206 204

Гаралт

204 205 206

Тайлбар

204 тоо хоёр дараалалд хоёуланд нь байгаа. Гэвч arr дараалалд 2 ширхэг байгаа бол brr дараалалд 3 ширхэг байна.

Үүнтэй адилаар 205, 206 нь arr дараалалд 2 ширхэг байгаа боловч brr дараалалд 3 ширхэг орсон байна.

Бусад бүх тоонууд адил давтамжтайгаар хоёр дараалалд орсон байна.

Орчуулсан : Б.Мөнхбаяр АНУ